



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/129

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд Чингис хотод шинээр байгуулахаар төлөвлөж буй ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулахтай холбогдуулан Дорнод аймгаас туршлага судлах ажилд 625,000.0 (зургаан зуун хэрин таван мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010352